**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хүүхдийн урлан бүтээх төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/496/НА-СТА-ТШЗ



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br><br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn<br><br>Гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа<br>Утас: 99108763, Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 271

танай ______________-ны № ________________-т

ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Д.УРАНБИЛЭГ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн урлан бүтээх төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн,мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хүүхдийн урлан бүтээх төв нь тайлант онд үзэсгэлэнгийн танхимдаа 21 үзэсгэлэн зохион байгуулсан бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Элчин Сайдын яамтай хамтран "Нөхөрлөлийн өнгө" үзэсгэлэнд 1500 бүтээл, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Элчин Сайдын яамтай хамтран "Өнгөөр урласан нөхөрлөл" үзэсгэлэнд 800 гаруй бүтээл мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагддаг "Мөнх тэнгэрийн бичиг" олон улсын үзэсгэлэнд 350 гаруй бүтээл оролцуулж хүүхдийн уран бүтээлийг үндэсний болон олон улсын түвшинд авьяас чадварыг нь хөгжүүлэхэд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 23 ширхэг 102.1 сая төгрөгийн суурин компьютерыг шилжүүлэн авснаар байгууллагын техник, технологийн хангамж сайжирч, үйл ажиллагааг шуурхай, тасралтгүй хэрэгжүүлэх боломж нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt - docx

1426050127

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt -.docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **72,833,742.00** | **58,641,206.52** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **6,968,500.00** | **-** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **6,968,500.00** | **-** |
| **3121** | **Төгрөг** | **6,968,500.00** | **-** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 6,968,500.00 | - |
| **33** | **АВЛАГА** | **12,033,045.00** | **8,690,408.52** |
| 335 | Бусад авлага | 12,033,045.00 | 8,690,408.52 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 12,033,045.00 | 8,690,408.52 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **53,832,197.00** | **49,950,798.00** |
| 354 | Хангамжийн материал | 53,832,197.00 | 49,950,798.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,711,484.00 | 1,057,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,833,830.00 | 15,130,330.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 20,725,433.00 | 18,201,818.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,561,450.00 | 15,561,450.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,765,534,872.16** | **2,704,334,903.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,765,534,872.16** | **2,704,334,903.79** |
| **392** | **Биет хөрөнгө** | **2,544,703,272.16** | **2,483,503,303.79** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,364,424,152.00 | 3,364,157,272.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,018,264,338.89) | (1,148,773,131.17) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 223,345,527.00 | 310,892,520.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (58,016,001.98) | (73,538,113.84) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 82,876,497.10 | 75,968,942.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (66,639,063.07) | (62,180,685.90) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 16,976,500.00 | 16,976,500.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **220,831,600.00** | **220,831,600.00** |
| 39301 | Програм хангамж | 1,298,500.00 | 1,298,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,298,500.00) | (1,298,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 220,831,600.00 | 220,831,600.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,838,368,614.16** | **2,762,976,110.31** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **8,548,299.27** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **8,548,299.27** | **-** |
| **413** | **Өглөг** | **8,548,299.27** | **-** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,579,799.27 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 6,968,500.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,829,820,314.89** | **2,762,976,110.31** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,829,820,314.89** | **2,762,976,110.31** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | **690,309,419.70** | **690,309,419.70** |
| 51101 | Өмч: - төрийн | 690,309,419.70 | 690,309,419.70 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **(1,033,728,836.03)** | **(1,100,293,784.61)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (1,033,728,836.03) | (1,033,449,580.03) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (66,844,204.58) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,173,239,731.22 | 3,172,960,475.22 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,838,368,614.16** | **2,762,976,110.31** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,696,256,860.69** | **2,025,636,808.69** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **40,551,285.96** | **144,281,352.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **40,551,285.96** | **144,281,352.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **40,551,285.96** | **42,216,192.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,132,925.96 | 42,216,192.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 25,418,360.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,655,705,574.73** | **1,881,355,456.69** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,087,000.00** | **8,543,200.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,087,000.00 | 8,543,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,513,248,574.73** | **1,872,812,256.69** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,513,248,574.73 | 1,872,812,256.69 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **139,370,000.00** | **-** |
| 133003 | Хөрөнгийн | 139,370,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,679,686,888.65** | **2,092,481,013.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,672,718,388.65** | **2,092,481,013.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,638,030,522.23** | **2,004,087,251.94** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,141,850,226.75** | **1,459,390,285.54** |
| 210101 | Үндсэн цалин | 653,112,549.46 | 758,734,682.26 |
| 210102 | Нэмэгдэл | 159,235,948.87 | 208,887,123.27 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 222,625,893.86 | 361,250,592.01 |
| 210104 | Урамшуулал | 106,875,834.56 | 130,517,888.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **142,785,082.08** | **183,093,129.99** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 99,044,965.86 | 127,639,966.01 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,869,614.09 | 14,790,201.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,196,134.04 | 8,202,121.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,435,651.01 | 6,504,706.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,238,717.08 | 25,956,134.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **64,615,544.71** | **71,907,522.54** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,662,093.74 | 32,760,938.05 |
| 210302 | Түлш, халаалт | 33,087,435.76 | 34,204,898.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,866,015.21 | 4,941,685.89 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **21,739,999.00** | **22,339,628.50** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,454,400.00 | 2,565,434.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,434,000.00 | 478,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,426,400.00 | 3,595,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,560,000.00 | 7,986,494.50 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,865,199.00 | 7,714,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **26,369,236.00** | **25,787,800.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 560,000.00 | 110,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 25,809,236.00 | 25,677,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,389,150.00** | **5,656,152.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 278,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,800,000.00 | 2,800,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,158,000.00 | 1,147,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,431,150.00 | 1,431,152.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **231,281,283.69** | **235,912,733.37** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,087,000.00 | 8,375,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 74,557,235.00 | 64,272,405.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 153,637,048.69 | 163,265,128.37 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **34,687,866.42** | **88,393,761.33** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **34,579,358.50** | **58,477,569.33** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,946,113.50 | 53,944,969.33 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,633,245.00 | 4,532,600.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **108,507.92** | **29,916,192.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 108,507.92 | 29,916,192.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,968,500.00** | **-** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 6,968,500.00 | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | 6,968,500.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **16,569,972.04** | **(66,844,204.58)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **16,569,972.04** | **(66,844,204.58)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,677,807,000.69** | **1,923,571,648.69** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **22,101,425.96** | **42,216,192.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **22,101,425.96** | **42,216,192.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 22,101,425.96 | 42,216,192.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,132,925.96 | 42,216,192.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,968,500.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,655,705,574.73** | **1,881,355,456.69** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,087,000.00** | **8,543,200.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,087,000.00 | 8,543,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,513,248,574.73** | **1,872,812,256.69** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,513,248,574.73 | 1,872,812,256.69 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **139,370,000.00** | **-** |
| 133003 | Хөрөнгийн | 139,370,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,531,468,500.69** | **1,923,571,648.69** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,531,468,500.69** | **1,923,571,648.69** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,496,780,634.27** | **1,835,177,887.36** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,153,883,271.75** | **1,457,470,084.81** |
| 210101 | Үндсэн цалин | 665,145,594.46 | 756,814,481.53 |
| 210102 | Нэмэгдэл | 159,235,948.87 | 208,887,123.27 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 222,625,893.86 | 361,250,592.01 |
| 210104 | Урамшуулал | 106,875,834.56 | 130,517,888.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **141,205,282.81** | **183,250,493.51** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 97,465,166.59 | 127,797,329.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,869,614.09 | 14,790,201.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,737,447.04 | 8,202,121.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,894,338.01 | 6,504,706.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,238,717.08 | 25,956,134.58 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **64,615,544.71** | **71,907,522.54** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,662,093.74 | 32,760,938.05 |
| 210302 | Түлш, халаалт | 33,087,435.76 | 34,204,898.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,866,015.21 | 4,941,685.89 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **22,474,199.00** | **21,091,844.50** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,454,400.00 | 1,421,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,434,000.00 | 478,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,426,400.00 | 3,595,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,560,000.00 | 7,986,494.50 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,599,399.00 | 7,611,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **26,399,236.00** | **25,787,800.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 560,000.00 | 110,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 25,839,236.00 | 25,677,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,389,150.00** | **5,378,152.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,800,000.00 | 2,800,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,158,000.00 | 1,147,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,431,150.00 | 1,431,152.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **78,813,950.00** | **70,291,990.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,087,000.00 | 8,543,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 75,726,950.00 | 61,748,790.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 34,687,866.42 | 88,393,761.33 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 34,579,358.50 | 58,477,569.33 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,946,113.50 | 53,944,969.33 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,633,245.00 | 4,532,600.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **108,507.92** | **29,916,192.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 108,507.92 | 29,916,192.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **139,370,000.00** | **6,968,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **139,370,000.00** | **6,968,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **139,370,000.00** | **6,968,500.00** |
| 222001 | Тоног төхөөрөмж | 139,370,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 6,968,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(139,370,000.00)** | **(6,968,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **6,968,500.00** | **(6,968,500.00)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **6,968,500.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **6,968,500.00** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **690,309,419.70** | **3,173,239,731.22** | **(1,057,267,308.07)** | **2,806,281,842.85** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 690,309,419.70 | 3,173,239,731.22 | (1,057,267,308.07) | 2,806,281,842.85 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 23,538,472.04 | 23,538,472.04 |
| **2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **690,309,419.70** | **3,173,239,731.22** | **(1,033,728,836.03)** | **2,829,820,314.89** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 279,256.00 | 279,256.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 690,309,419.70 | 3,173,239,731.22 | (1,033,449,580.03) | 2,830,099,570.89 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (279,256.00) | - | (279,256.00) |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (66,844,204.58) | (66,844,204.58) |
| **2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **690,309,419.70** | **3,172,960,475.22** | **(1,100,293,784.61)** | **2,762,976,110.31** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,240,071,400.00** | **1,885,112,256.69** | **354,959,143.31** | **84.2** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,227,771,400.00** | **1,842,896,064.69** | **384,875,335.31** | **82.7** |
| **132001** | **Орон нутгийн төсвөөс** | **2,227,771,400.00** | **1,842,896,064.69** | **384,875,335.31** | **82.7** |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **12,300,000.00** | **42,216,192.00** | **(29,916,192.00)** | **343.2** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,300,000.00 | 42,216,192.00 | (29,916,192.00) | 343.2 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,240,071,400.00** | **1,885,112,256.69** | **354,959,143.31** | **84.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,240,071,400.00** | **1,885,112,256.69** | **354,959,143.31** | **84.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,173,551,100.00** | **1,826,634,687.36** | **346,916,412.64** | **84.0** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил ,** | **1,703,123,600.00** | **1,457,470,084.81** | **245,653,515.19** | **85.6** |
| 210101 | Үндсэн цалин | 849,454,300.00 | 756,814,481.53 | 92,639,818.47 | 89.1 |
| 210102 | Нэмэгдэл | 212,363,600.00 | 208,887,123.27 | 3,476,476.73 | 98.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 499,730,000.00 | 361,250,592.01 | 138,479,407.99 | 72.3 |
| 210104 | Урамшуулал | 141,575,700.00 | 130,517,888.00 | 11,057,812.00 | 92.2 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **212,890,400.00** | **183,250,493.51** | **29,639,906.49** | **86.1** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 144,765,500.00 | 127,797,329.53 | 16,968,170.47 | 88.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,031,200.00 | 14,790,201.20 | 2,240,998.80 | 86.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,515,600.00 | 8,202,121.32 | 313,478.68 | 96.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,515,600.00 | 6,504,706.88 | 2,010,893.12 | 76.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,062,500.00 | 25,956,134.58 | 8,106,365.42 | 76.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **115,132,000.00** | **71,907,522.54** | **43,224,477.46** | **62.5** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 34,044,100.00 | 32,760,938.05 | 1,283,161.95 | 96.2 |
| 210302 | Түлш, халаалт | 76,449,400.00 | 34,204,898.60 | 42,244,501.40 | 44.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,638,500.00 | 4,941,685.89 | (303,185.89) | 106.5 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,444,000.00** | **21,091,844.50** | **7,352,155.50** | **74.2** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,500,000.00 | 1,421,150.00 | 78,850.00 | 94.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,825,000.00 | 478,000.00 | 3,347,000.00 | 12.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,272,000.00 | 3,595,000.00 | 677,000.00 | 84.2 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | - | 500,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 9,246,000.00 | 7,986,494.50 | 1,259,505.50 | 86.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,101,000.00 | 7,611,200.00 | 1,489,800.00 | 83.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **27,003,900.00** | **25,787,800.00** | **1,216,100.00** | **95.5** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 579,900.00 | 110,000.00 | 469,900.00 | 19.0 |
| 210604 | Урсгал засвар | 26,424,000.00 | 25,677,800.00 | 746,200.00 | 97.2 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,800,000.00** | **-** | **4,800,000.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,800,000.00 | - | 4,800,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,157,200.00** | **5,378,152.00** | **779,048.00** | **87.3** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,500,000.00 | 2,800,000.00 | 700,000.00 | 80.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,225,000.00 | 1,147,000.00 | 78,000.00 | 93.6 |
| 210807 | Газрын төлбөр | 1,432,200.00 | 1,431,152.00 | 1,048.00 | 99.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **76,000,000.00** | **61,748,790.00** | **14,251,210.00** | **81.2** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 76,000,000.00 | 61,748,790.00 | 14,251,210.00 | 81.2 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **66,520,300.00** | **58,477,569.33** | **8,042,730.67** | **87.9** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **66,520,300.00** | **58,477,569.33** | **8,042,730.67** | **87.9** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 54,231,700.00 | 53,944,969.33 | 286,730.67 | 99.5 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,288,600.00 | 4,532,600.00 | 7,756,000.00 | 36.9 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **6,968,500.00** | **(6,968,500.00)** | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **6,968,500.00** | **(6,968,500.00)** | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 59 | 49 | 10 | 83.1 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 42 | 33 | 9 | 78.6 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16 | 15 | 1 | 93.8 |

## 2.6 Аудит хийсэн Нэмэлт санхүүжилтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **8,543,200.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **8,543,200.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 8,543,200.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **8,543,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **8,543,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **8,543,200.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **-** | **8,543,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 8,543,200.00 |

Илрүүлэлт: Тайлант хугацаанд төсвийн шууд захирагч 2,636,315.9 мянган төгрөгийн 171 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас 163 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 гүйлгээний 1,550,399.1 мянган төгрөг, зарлагын 7 гүйлгээний 68,635.3 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээ, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг огт байршуулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;*, 6.10-т “*Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна”* гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, батлагдсан төсвийг хуваах замаар 25,137.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "*Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно*", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т *“Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”,* 10 дугаар зүйлийн 10.3-т “*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

***Илрүүлэлт-1*** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2882 ширхэг 209,769.9 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох арга хэмжээ аваагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох“ 7.1-д *“төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргүүлж шийдвэрлүүлнэ”* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг НӨХГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх.

**Илрүүлэлт-2**: Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад хөрөнгө тоолсон тухай илтгэх хуудас, тооллогын тайлан, тооцоо бодсон акт үйлдээгүй байна

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 -т *"комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх",* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т *“холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”* гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгийн тооллогын тооцоог бодож, хөрөнгийн дансны үлдэгдэлтэй тулган шалгаж байх.

***Илрүүлэлт**:* Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "*Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна*", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-т "*Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана*" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж*:*

Санхүүгийн тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан тодруулга тайланг бэлтгэж байх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад хөрөнгө тоолсон тухай илтгэх хуудас, тооллогын тайлан, тооцоо бодсон акт үйлдээгүй байна | 1 | - | - | - | - | - | 1 | - | | | | |
| 2 | Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 2882 ширхэг 209,769.9 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. | 1 | - | - | - | | | 1 | - | | | | |
| 3 | Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайлан бэлтгээгүй байна. | 1 | - | - | - | | | 1 | - | | | | |
| | **Дүн** | **3** | - | **-** | **-** | **-** | **-** | **3** | - | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөг/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16 гүйлгээний 2,554,485.2 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, нийтийн албанд нийтийн болон | 1 | 1,619,034.4 | - | - | 1 | 1,619,034.4 | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг байршуулаагүй байна. | | | | | | | | |
| **Дүн** | 1 | 1,619,034.4 | **-** | **-** | 1 | 1,619,034.4 | **-** | **-** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулалгүй төсөвт өртгийг хуваах худалдан авалт хийсэн байна. | 1 | 25,137.2 | | | 1 | 25,137.2 | | |
| **Дүн** | 1 | 25,137.2 | - | - | 1 | 25,137.2 | - | - |
| **НИЙТ** | 2 | 1,644,171.6 | - | - | 2 | 1,644,171.6 | - | - |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 76/20310579 Улаанбаатар хот

НТАГ-2026/496/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхдийн урлан бүтээх төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, батлагдсан төсвийг хуваах замаар 25,137,200.00 (хорин таван сая нэг зуун гучин долоон мянга хоёр зуу) төгрөгийн бараа материалын худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "*Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно*", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "*Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална*". 10 дугаар зүйлийн 10.3-т "*Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно*" гэж заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхдийн урлан бүтээх төвийн дарга Д.Уранбилэг, нягтлан бодогч Б.Оюунбилэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА

1426090139

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 77/2081/0579 Улаанбаатар хот

НТАГ-2026/496/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүүхдийн урлан бүтээх төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим цэсэнд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 гүйлгээний 1,550,399,100.00 (нэг тэрбум таван зуун тавин сая гурван зуун ерэн есөн мянга нэг зуу) төгрөг, зарлагын 7 гүйлгээний 68,635,300.00 (жаран найман сая зургаан зуун гучин таван мянга гурван зуу) төгрөгийн мөнгөн гүйлгээ, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг байршуулаагүй, 8 мэдээллийг хугацаа хоцроож, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*", 6.10-т "*Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна*" гэж заасантай нийцэхгүй байна.

**Иймд** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.10 "*аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*", 4.2.1.11 "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхдийн урлан бүтээх төвийн дарга Д.Уранбилэг, нягтлан бодогч Б.Оюунбилэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА

1426090141